

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ
ЗАХИРАЛ БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛИЙН
2023 оны 5 сарын 15 өдөр



**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛИЙН
6, 7 ДУГААР АНГИД СУРАГЧ ЭЛСҮҮЛЭХ УДИРДАМЖ**

ЗОРИЛГО: Өөрийн суралцах зорилгыг Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургууль (ЕБШМС)-ийн бодлого, зорилготой нэгтгэн, сорилтыг даван туулж, амжилтад хүрэх хүсэл, эрмэлзэлтэй сурагчдад боломж олгох үүднээс 6, 7 дугаар ангийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

ЭЛСЭХ СУРАГЧДАД ТАВИХ ШААРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОО:

Анги	6-р анги	7-р анги
Элсэгчдэд тавигдах шаардлага	5-р анги төгссөн байх	6-р анги төгссөн байх
Элсүүлэх сурагчийн тоо	25 сурагч	25 сурагч

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

№	Зохион байгуулалт	Хугацаа	Хэлбэр
1	Зар мэдээллийг олон нийтэд хүргэх	5 сарын 17-ноос	цахим суваг
2	Элсэхийг хүсэгчдийг бүртгэх	5 сарын 20-ноос 6 сарын 08	онлайн
3	Бичгийн шалгалт зохион байгуулах	6 сарын 10	танхим
4	Шалгалтын дүн гаргах, шалгуулагчдад мэдээлэл хүргэх	6 сарын 11	цахимаар
5	Элсэх болзол хангасан сурагчдад батламж гардуулах	6 сарын 12	биечлэн
6	Элсэх болзол хангасан сурагчдын эцэг эхтэй гэрээ байгуулах	6 сарын 12-16	биечлэн

ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ:

1. Элсэхийг хүсэгчдийг 2023 оны 05 сарын 20-ны өдрийн 16:00 цагаас 06 сарын 08-ны өдрийн 16:00 цагийг дуустал <http://202.21.114.244/shinemongol-dund/> цахим хаягаар бүртгэж, бүртгэлийн дугаар олгох ба бүртгүүлэгч нь регистрийн дугаараар цахим бүртгэлд зөвхөн нэг удаа хандах боломжтой.
2. Бүртгүүлэгчийн овог нэр, регистрийн дугаарыг кирил үсгээр алдаагүй бичнэ.
3. Бүртгүүлэгчийн цээж зургийг JPEG, PNG, JPG өргөтгөлөөр оруулах бөгөөд зурган файлыг сурагчийн нэрээр нэрлэсэн байна.
4. Бүртгэлийн хураамж 15'000 төгрөгийг <http://202.21.114.244/shinemongol-dund/> хаягаар орж QPAY үйлчилгээг ашиглан, QR код уншуулан төлнө. **Голомт банкаар** тооцоо хийх **боломжгүйг** анхааруулж байна.
5. Бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг бүртгүүлсэн e-mail хаягаар илгээх тул тогтмол ашигладаг e-mail хаяг, холбоо барих утасны дугаарыг заавал бичнэ.
6. Бүртгэл амжилттай болсноор бүртгүүлэгч цахим бүртгэлийн системд нэвтрэх эрхтэй болох бөгөөд 06 сарын 09-ний өдрийн 16:00 цагт бүртгэлийн системд шалгалт өгөх анги, суудлын дугаар тавигдсан байна.

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН АГУУЛГА, ХЭЛБЭР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

1. Шалгалт нь БШУЯ-наас баталсан математик, монгол хэлний хичээлийн бага болон суурь боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн үндсэн агуулгын хүрээнд байна.

2. Элсэлтийн шалгалтыг 2023 оны 06 сарын 10-нд 10:00-12:00 цагийн хооронд танхимаар зохион байгуулна. Үүнд:

Анги	Шалгалт авах хичээл	Шалгалтын хугацаа	Шалгалтын дээд оноо
6-р анги	Монгол хэл	40 минут	30
	Математик	60 минут	70
7-р анги	Монгол хэл	40 минут	30
	Математик	60 минут	70

3. Шалгалтад ирэхдээ бүртгэлийн системээс бүртгэлийн хуудсаа хэвлэж авчрах ба шалгалт эхлэхээс 10 минутын өмнө шалгалт өгөх ангид ирсэн байна.
4. Монгол хэл, математикийн шалгалтын нийлбэр дүн, гүйцэтгэлийн хувиар шалгуулагчдыг эрэмбэлж, анги тус бүрд эхний 25 сурагчид элсэн суралцах эрх олгоно.

ДҮН МЭДЭЭ:

- Шалгалтын дүнг 2023 оны 06 сарын 11-ний 10:00 цагт багтаан бүртгэлийн дугаараар нь "Шинэ Монгол сургууль" фэйсбүүк хуудас болон цахим бүртгэлийн системээр мэдээлнэ.
- Шалгалтад тэнцсэн сурагчид эцэг эхийн хамт 2023 оны 06 сарын 12-ны өдөр элсэн суралцах батламжийг сургуулийн захирлаас гардан авна. Батламж олгох хуваарийг цахим бүртгэлийн системд байршуулна.

ХОЛБОО БАРИХ: Сургуулийн утас 7777-5599
Элсэлттэй холбоотой асуултыг 80967787
Цахим бүртгэлтэй холбоотой асуултыг 99012097
Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, өргөдлийг school@shinemongol.edu.mn хаягаар тус тус хүлээж авна.

СУРГУУЛИЙН ЗАХИРГАА